

Балжирсүрэнгийн Ганцэцэг¹✉, Пүрэвийн Баянсан²

¹Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяа Удирдлагын академи,
Монгол Улс, Улаанбаатар-17012, Хан-уул дүүрэг,
Удирдлагын академийн гудамж-100

²Монгол Улсын Их Сургуулийн Бизнесийн сургууль,
Монгол улс, Улаанбаатар, Бага тойруу,
Их сургуулийн өргөн чөлөө, хичээлийн 4-р байр

**Археологийн салбар дахь оюуны өмчийн эрх: Монгол улсын
эрх зүйн зохицуулалт, өмчлөл, үнэлгээний асуудлууд**

Хураангуй. Соёлын өвийг хамгаалах, шинжлэх ухааны судалгааг хөгжүүлэх, түүнчлэн судалгааны үр дүнг эдийн засгийн эргэлтэд үр ашигтай ашиглах шаардлага нэмэгдэхийн хэрээр археологийн судалгаа, археологийн олдвор болон оюуны өмчийн эрх зүйн харилцааны уялдаа холбоо онцгой ач холбогдолтой асуудал болж байна. Энэхүү өгүүлэлд Монгол Улсад археологийн судалгааны үр дүнд бий болох оюуны өмчийн эрхийн харилцааг өмчлөл, зохиогчийн эрх, биет бус хөрөнгийн үнэлгээ болон ашиглалтын эрх зүйн зохицуулалтын хүрээнд шинжилсэн болно. Судалгаанд харьцуулсан эрх зүйн аргыг ашиглаж, Монгол Улсын Үндсэн хууль, Оюуны өмчийн тухай хууль, Зохиогчийн эрхийн тухай хууль, Патентийн тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль зэрэг үндэсний хууль тогтоомжийн зохицуулалтыг судлан дүн шинжилгээ хийв. Судалгааны үр дүнгээс үзэхэд археологийн олдворын төрийн өмчийн эрхийн хүрээ, археологич болон судлаачдын зохиогчийн эрхийн хамгаалалт, мөн археологийн судалгаанаас үүсэх биет бус хөрөнгийн үнэлгээ, ашиглалттай холбоотой эрх зүйн зохицуулалтад тодорхойгүй байдал, эрх зүйн хийдэл оршоор байгаа нь тогтоогдов. Иймд энэхүү өгүүлэл нь археологийн өвийг нийтийн өмчийн шинжтэйгээр хамгаалах зарчим, судлаачдын оюуны хөдөлмөрийн эрхийг зохистойгоор баталгаажуулах шаардлага, мөн соёлын өвд суурилсан тогтвортой мэдлэгийн эдийн засгийг хөгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх боломж, чиг хандлагыг тодорхойлохыг зорьсон болно.

Түлхүүр үг: оюуны өмч, археологи, соёлын өв, зохиогчийн эрх, биет бус хөрөнгө, лиценз, амины эрх, өмчлөх эрх

Gantsetseg Baljirsuren¹✉, Bayansan Purev²

¹Department of Policy and Political Studies,
the National Academy of Governance,
Udirdlagyn Academy street-100,
Ulaanbaatar 17012, Mongolia

²Business School, the National University of Mongolia,
Baga Toiruu, University Avenue, Build No. 4,
Ulaanbaatar-14201, Mongolia

**Intellectual Property in Archaeology: Legal regulation, ownership, and
valuation issues in Mongolia**

Abstract. The interaction between intellectual property (IP) law and archaeology has become increasingly significant in the context of cultural heritage protection, scientific research, and economic utilization of research outputs. This paper analyzes the legal nature of intellectual property arising from archaeological research in Mongolia, focusing on ownership, authorship, valuation, and commercialization issues. Using doctrinal legal analysis and comparative approaches, the study examines national legislation, including the Constitution of Mongolia, the Law on Intellectual Property, the Law on Copyright, the Patent Law, and the Law on Protection of Cultural Heritage. The findings highlight existing legal gaps related to authors' rights, state ownership of archaeological finds, and the valuation of intangible assets derived from archaeological research. The paper proposes a conceptual framework for balancing public ownership of cultural heritage with the intellectual property rights of archaeologists and research institutions.

Keywords: intellectual property, archaeology, cultural heritage, copyright, intangible assets, license, moral rights, property rights

Оршил

Археологийн судалгаа нь түүхэн мэдлэгийг сэргээн тогтоох, соёлын өвийг хамгаалах, үндэсний үнэт зүйлийг хадгалах үйл ажиллагааны чухал хэсэг юм. Үүний зэрэгцээ археологийн судалгаа нь эрдэм шинжилгээний өгүүлэл, тайлан, өгөгдлийн сан, гэрэл зураг, газрын зураг, дижитал загвар, тайлбар дүн шинжилгээ зэрэг олон төрлийн оюуны бүтээлийг бий болгодог.

Эдгээр оюуны бүтээл нь зохиогчийн эрх болон бусад оюуны өмчийн хамгаалалтад хамаарах боломжтой хэдий ч Монгол Улсын эрх зүйн орчинд археологийн олдвор нь төрийн болон нийтийн өмчид хамаардаг тул өмчлөл, ашиглалт, эдийн засгийн эргэлтэд оруулах асуудалд эрх зүйн тодорхой бус байдал үүсдэг. Энэхүү өгүүллийн зорилго нь Монгол Улс дахь археологи ба оюуны өмчийн эрх зүйн уялдаа холбоог судалж, тулгамдсан асуудлыг тодорхойлох явдал юм.

Оюуны өмчийн ойлголт ба эрх зүйн зохицуулалт

А. Оюуны өмчийн ойлголт

Оюуны өмч гэдэг нь хүний бүтээлч сэтгэлгээний үр дүнд бий болсон, биет болон биет бус хэлбэрээр илэрхийлэгдсэн бүтээлийг хэлнэ. Үүнд аж үйлдвэрийн өмч (шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдэг) болон зохиогчийн эрхээр хамгаалагдах бүтээл (шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл) хамаарна. Оюуны өмч нь эдийн засгийн хувьд нийтийн барааны шинжтэй буюу нэг этгээдийн хэрэглээ нь нөгөө этгээдийн хэрэглээг хязгаарладаггүй, өрсөлдөөнгүй шинжтэй байдаг тул тусгайлсан эрх зүйн хамгаалалт шаарддаг.

Оюуны өмч (ОӨ) гэдэг нь хүний бүтээлч болон шинжлэх ухааны оюуны үйл ажиллагааны үр дүнд бий болж, тодорхой хэлбэрээр (бичвэр, зураг, дүрс, өгөгдөл, программ, дизайн, тэмдэг, аргачлал гэх мэт) илэрхийлэгдсэн, хуульчлан хамгаалагдах боломжтой биет бус хөрөнгө юм. Эдийн засгийн онолоор оюуны өмч нь нэг талдаа нийтийн барааны шинжийг агуулдаг тул (ялангуяа мэдлэг, мэдээллийн түвшинд), нөгөө талдаа хуулиар олгосон онцгой эрхээр дамжин зах зээл дээр үнэ цэн бүтээдэг “институцийн зохицуулалттай капитал” юм.

Энэ “биет бус капитал” дэлхийн эдийн засгийн бүтцэд бодитоор давамгайлах болсон нь олон эх сурвалжаар баталгаажиг байна. Тухайлбал Ocean Tomo [10]-ийн судалгаагаар S&P 500 компанийн зах зээлийн үнэлгээнд биет бус хөрөнгийн эзлэх хувь 2020 онд ойролцоогоор 90%-ийн түвшинд хүрсэн гэж тэмдэглэсэн байдаг. Ocean Tomo Мөн WIPO–Luiss Business School [19]-ийн хамтарсан тайланд 2008–2024 онд биет бус хөрөнгөд хийсэн

хөрөнгө оруулалтын өсөлт нь биет хөрөнгө оруулалтаас 3.7 дахин хурдтай өссөн бөгөөд 1995–2024 хооронд биет бус хөрөнгө оруулалт бодитоор 143% өссөн (биет хөрөнгө оруулалт 32%) гэж тооцсон байна (WIPO, 2024).

Эдгээр хандлага нь археологийн салбарт ч шууд хамаарна. Учир нь археологи нь төрийн өмчийн (олдвор, дурсгалт газар) суурин дээр, шинжлэх ухааны тайлбар, баримтжуулалт, өгөгдөлжүүлэлт гэх мэт оюуны хөдөлмөрөөр, контент ба мэдээлэл (тайлан, өгүүлэл, зураг, 3D, өгөгдлийн сан, музейн тайлбар, сургалтын материал) үйлдвэрлэдэг “оюуны үйлдвэрлэл” болж хувирч байна. Түүх, соёлын дурсгал, археологийн олдвор нь байгаагаараа зохиогчийн бүтээл биш тул ихэнх тохиолдолд “зохиогчийн эрхийн объект” болохгүй. Харин дурсгал дээр хийсэн судалгаанаас үүсэх дараах оюуны үр дүн оюуны өмчийн хамгаалалтад бүрэн хамрагдана. Үүнд:

- малтлага, хайгуулын дэлгэрэнгүй тайлан, шинжилгээний өгүүлэл
- олдворын гэрэл зураг, дүрслэл, хэмжилтийн зураглал
- газрын зураг, мэдээллийн сан, дата ба метадата
- 3D сэргээн босголт, VR/AR контент, виртуал музейн материал
- ангилал, тайлбар, “өмнөх үеийн технологи, хэв маяг”-ийн шинжлэх ухааны үзүүлэн

Эндээс үзэхэд археологийн салбарт давхар өмчлөх эрхийн бүтэц үүсдэг бөгөөд нэгдүгээрт соёлын өвийн материаллаг объект буюу нийтийн, төрийн өмч, хоёрдугаарт судалгааны оюуны үр дүн нь зохиогчийн эрх, өгөгдлийн эрх, лицензийн гэрээ, байгууллагын эзэмшил гэх мэтээр зохицуулагдах биет бус хөрөнгө болдог байна. Энэхүү давхар бүтэц нь музейн дэлгэн үзүүлэх, нийтлэх, дижиталжуулах, лиценз олгох үед “хэн зөвшөөрөл өгөх вэ?”, “хэн орлого хүртэх вэ?”, “нээлттэй өгөгдөл ба нууцлалын тэнцвэрийн тухай” зэрэг бодит маргаан үүсгэдэг.

Соёлын өвийн “материаллаг үнэ цэн” нь зөвхөн хамгаалалтын асуудал биш бөгөөд зөв бодлогоор “оюуны үнэ цэн” болон хувирч, улмаар биет бус хөрөнгө, үйлчилгээ, бүтээлч эдийн засгийн салбарт ордог байна. Энэ нь дэлхийн хэмжээнд тоон үзүүлэлтээр илэрхий болж байна.

UNESCO-ийн мэдээллээр соёл, бүтээлч үйлдвэрлэлийн салбарууд (cultural and creative industries) дэлхийн ДНБ-ий 3.39%, нийт ажлын байрны 3.55%-ийг бүрдүүлдэг бөгөөд 250 хотын жишээгээр соёлын аялал жуулчлал 2023 онд USD 741.3 тэрбум долларын орлого бий болгосон гэж тэмдэглэгдсэн байдаг [11]. Мөн UNCTAD-ийн тайланд бүтээлч үйлдвэрлэлийн эдийн засгийн хувь

нэмэр улс орнуудаар 0.5%–7.3%-ийн ДНБ хүртэл хэлбэлзэж болохыг олон улсын судалгаагаар нэгтгэн харуулсан [14]. Эдгээр баримт нь археологийн судалгаа болон малтлага зөвхөн “тайлан гаргах”-аар хязгаарлахгүй, харин:

- музейн тайлбар, үзэсгэлэнгийн өгүүлэмж,

- боловсролын контент,
- дижитал архив/платформ,
- лицензийн гэрээ,
- аялал жуулчлалын бүтээлч бүтээгдэхүүн зэргээр дамжин биет бус хөрөнгийн урсгал үнэ цэн бий болгож болдгийг нотолж байна.

Хүснэгт 1. Соёлын өв, оюуны өмч, биет бус хөрөнгийн уялдааг нотлох тоон үзүүлэлт

ОУБ	Үзүүлэлт	Тоон утга	Тайлбар / ач холбогдол
UNESCO[11]	Соёл, бүтээлч үйлдвэрлэлийн салбарын дэлхийн ДНБ-д эзлэх хувь	3.39%	Соёлын контент, өв дээр суурилсан эдийн засгийн бодит жин
UNESCO[11]	Соёл, бүтээлч үйлдвэрлэлийн салбарын нийт ажил эрхлэлтэд эзлэх хувь	3.55%	Соёлын салбар хөдөлмөрийн зах зээлийн хэмжээс
UNESCO[11]	Соёлын аялал жуулчлалын орлого (250 хот, 2023)	USD 741.3B	Соёлын өвийн үйлчилгээ/туршлага, орлого
UNCTAD[14]	Бүтээлч эдийн засгийн ДНБ-д эзлэх хувь (улсуудаар)	0.5%–7.3%	Улсаас хамаарч бодлогоор өсгөх боломжтой
WIPO-LBS[19]	Биет бус хөрөнгө оруулалтын өсөлт (2008–2024)	3.7 дахин хурдтай	Биет бус хөрөнгө нь “шинэ капитал” өссөн байдал
WIPO-LBS[19]	Биет бус хөрөнгө оруулалтын өсөлт (1995–2024)	+143%	Мэдлэг /өгөгдөл/-ийн оюуны өмчид төвлөрсөн урт хугацааны өсөлт
Ocean Tomo[10]	S&P 500 компанийн үнэлгээнд биет бус хөрөнгийн эзлэх хувь (2020)	Ойролцоогоор 90%	Зах зээл биет бус хөрөнгийг үнэ цэн гэж хүлээн зөвшөөрч буйг харуулна

Б. Монгол Улс дахь оюуны өмчийн эрх зүйн орчин

Монгол Улсад оюуны өмчийн эрх зүйн үндэс нь Үндсэн хуулийн 5, 7, 16 [1] дугаар зүйлд тусгагдсан. Үндсэн хуульд тулгуурлан дараах суурь хуулиуд хэрэгжиж байна. Үүнд:

- Оюуны өмчийн тухай хууль (2020),
- Зохиогчийн эрхийн тухай хууль (2021),
- Патентын тухай хууль (2021),
- Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль (2010) зэрэг болно.

Эдгээр хууль тогтоомж нь оюуны өмчийг бүтээх, бүртгэх, эзэмших, ашиглах, хамгаалах харилцааг зохицуулдаг бөгөөд албан үүргийн дагуу туурвисан бүтээлийн эрхийн асуудлыг ч тодорхойлдог.

Монгол Улсад оюуны өмчийн эрх зүйн үндэс нь Үндсэн хууль, Иргэний хууль болон салбарын тусгай хуулиуд юм. Оюуны өмчийн тухай хууль нь оюуны өмчийн эрхээр хамгаалагдах объект, хамгаалалтын зарчим, байгууллагын тогтолцоо, мөн оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулахыг дэмжих нийтлэг харилцааг зохицуулдаг бөгөөд хууль тогтоомжийн эх сурвалжийг Үндсэн хууль, Иргэний хууль, уг хууль болон тэдгээртэй нийцсэн бусад актаас бүрдэнэ гэж үздэг.

Мөн Зохиогчийн эрхийн тухай хууль нь зохиогчийн эрхийн харилцааг зохицуулахдаа Үндсэн хууль, Иргэний хууль, Оюуны өмчийн тухай хууль болон тухайн хуульд нийцсэн бусад актад тулгуурлахыг тогтоож, олон улсын гэрээний зохицуулалт зөрчилдвөл олон улсын гэрээг дагах зарчмыг мөн баталгаажуулдаг.

Соёлын өв, археологийн судалгаанд хэрэглэгдэх тусгай хууль нь Соёлын өвийг хамгаалах тухай хууль бөгөөд энэ хууль нь соёлын өвийг “судалж шинжлэх”, “үнэлэх”, “эзэмших, ашиглах, өмчлөх” зэрэг өргөн хүрээний харилцааг зохицуулдаг [5].

Олдвор ба дурсгалт орчны өмчлөлийн асуудал нь Соёлын өвийг хамгаалах тухай хуульд “түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол бүхий үнэт зүйл оршин байгаа нутаг дэвсгэр... төрийн хамгаалалтад байх бөгөөд аливаа олдвор нь төрийн өмч мөн” гэж тусгасан. Энэ нь археологийн олдворыг зах зээл дээр “хувийн өмч” болгон арилжаалах боломжийг эрх зүйн хувьд үндсэндээ үгүйсгэдэг [5].

Судалгааны оюуны үр дүнд бий болсон олдвор дээр суурилсан тайлан, өгүүлэл, зураг, өгөгдлийн сан, 3D модел, газрын зураг зэрэг нь зохиогчийн эрхийн объект болох боломжтой бөгөөд тухайн бүтээлийг “албан үүргийн дагуу” бүтээсэн эсэхээс шалтгаалан эрхийн хуваарилалт өөр өөр байна. Тухайлбал “албан үүргийн дагуу туурвисан бүтээл”-ийн хувьд зохиогч амины эрхээ эдэлнэ, харин ашиглах онцгой эрхийг талууд гэрээнд өөрөөр заагаагүй бол ажил олгогч эдэлнэ гэж хуульчилсан [1].

Эдгээр хоёр зарчим нэг дор үйлчлэх үед археологийн судалгаанд “төрийн өмч” (олдвор)-өөс “оюуны өмч” (судалгааны үр дүн) рүү шилжих эрх зүйн дамжлага үүсэж, практикт ашиглалт, лиценз, орлого хуваарилалт, нээлттэй өгөгдөл зэрэг асуудал дээр зохицуулалтын нарийвчлалыг шаардаж байна.

Соёлын өвийн судалгааг “мэргэжлийн эрдэм

шинжилгээний байгууллага” хийхээр тогтоосон нь археологийн судалгааны үйл ажиллагааг институцийн шүүлтүүртэй болгож байна [5]. Түүнчлэн палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрлийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санал, дүгнэлтэд үндэслэн олгох бөгөөд энэ төрлийн судалгааны журам нь холбогдох Засгийн газрын гишүүдийн хамтарсан шийдвэрээр батлагдана гэж заасан. Энэ нь археологийн судалгааны үр дүн (үүнд үүсэх оюуны өмчийн бүтээгдэхүүнүүд) “төрийн зөвшөөрөлтэй судалгаа”-наас үүсэх онцлогтойг харуулж байна [5].

Мөн газар олгох, барилга байгууламж, уул уурхай зэрэг эдийн засгийн үйл ажиллагаанаас өмнө археологи, угсаатны урьдчилсан судалгаа хийлгэх, дүгнэлт гаргуулах, зардлыг захиалагч хариуцах зэрэг зохицуулалт нь “авран хамгаалах” судалгааны эдийн засгийн суурийг бүрдүүлдэг [5].

Соёлын өвийн судалгааны ажлын дэлгэрэнгүй тайлангийн нэг хувийг улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд шилжүүлэх үүрэг нь археологийн судалгааны үр дүнг “төрийн мэдээллийн дэд бүтэц”-д төвлөрүүлэх зохицуулалттай [5].

Үүнээс гадна тухайн тайлан бүрэн эхээрээ нийтлэгдээгүй бол түүнийг ашиглах асуудлыг зохиогчийн эрхийн хууль-ийн дагуу шийдвэрлэнэ гэж Соёлын өвийг хамгаалах тухай хуульд заасан нь (29.2) “соёлын өвийн мэдээлэл, тайлан” болон “зохиогчийн эрх” хоёрын шууд холбоосыг хуульчилж өгсөн чухал хэрэг юм [5].

Иймд археологийн байгууллага, төслийн гэрээ, хамтын судалгаанд хамгийн багадаа дараах гурван зүйлийг гэрээгээр тодорхой болгох шаардлага үүсдэг байна. Үүнд:

- I (i) тайлан, өгөгдлийн сан, зураг, 3D материалын зохиогч, хамтран зохиогч
- II (ii) байгууллага, ажил олгогчийн ашиглах онцгой эрх ба лицензийн нөхцөл [2]
- III (iii) улсын бүртгэлд шилжүүлсэн тайлан, датад хандах, түгээх нээлттэй байдал, нууцлалын бодлого (ялангуяа эмзэг дурсгалын байршил, дээрэм тонуулын эрсдэлтэй үед).

Соёлын өвийг хамгаалах тухай хууль нь нийтийн өмчийн соёлын биет өвийг тодорхой байгууллагууд (жб., музей) эзэмшинэ гэж зааснаар хадгалалт, үзүүлэн, түгээх сувгуудыг бий болгосон байдаг [5].

Мөн соёлын биет өвийг өмчлөгчийн эрхэд “нийтэд дэлгэн үзүүлэх, сурталчлах, үзэсгэлэнд тавих, түүнээс олсон орлогоос авах” зэрэг эрхийг тусгасан нь соёлын өв дээр суурилсан үйлчилгээ, үзэсгэлэн, контентын эдийн засгийн боломжийг хуулийн түвшинд зөвшөөрсөн зохицуулалт гэж тайлбарлаж болох юм [5]. Гэхдээ археологийн

олдворын “төрийн өмч” статустай нөхцөлд энэ орлого хуваарилалтын (музей, төрийн байгууллага, судлаачид) механизм гэрээ, дотоод журам, салбарын нарийвчилсан бодлогоор шийдэгдэх шаардлагатай болдог байна.

Монгол Улс олон улсын түвшинд оюуны өмч болон соёлын өвийн гэрээ, хэлэлцээр нэгдсэн нь дотоод хууль тогтоомжийн тайлбар, бодлогын чиглэлд нөлөөлж байна. Тухайлбал: Монгол Улс WIPO-г үүсгэн байгуулсан конвенцод нэгдсэний үр дүнд 1979 оноос хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн байна [18]. Бернийн конвенцод (Paris Act 1971) Монгол Улс 1997-12-12-нд нэгдсэн [19]. Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн (1997-01-29) тул TRIPS-ийн минимум стандарт хэрэгждэг [17]. UNESCO-ийн Дэлхийн өвийн конвенцыг Монгол Улс 1990-02-02-нд хүлээн зөвшөөрсөн нь соёлын өвийн хамгаалалт, олон улсын хяналт, шалгууртай уялдах эрх зүйн суурь болдог [12]. Эдгээр олон улсын хүрээ нь археологийн өгөгдөл, нийтлэл, дижиталжуулалт, соёлын өвийн ашиглалт дээр “хамгаалалт хүртээмж” тэнцвэрийг тодорхойлох бодлогын суурь нөхцөл болж өгч байна.

Археологийн судалгаанд үүсэх оюуны өмчийн эрх

Археологийн олдвор нь хүний орчин үеийн бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болоогүй, түүхэн бодит баримт тул зохиогчийн эрхийн объект биш юм. Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлд зааснаар түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол бүхий аливаа олдвор нь төрийн өмч байна гэж хуульчилсан нь археологийн олдворыг өмчлөх, арилжаалах боломжийг үндсэндээ үгүйсгэдэг [5].

Гэсэн хэдий ч археологийн судалгааны явцад бий болсон оюуны үр дүн нь зохиогчийн эрхийн тухай хуулиар хамгаалагдана. Үүнд:

- археологийн хайгуул, малтлагын шинжлэх ухааны тайлан,
- эрдэм шинжилгээний өгүүлэл, ном, тайлбар,
- олдворын гэрэл зураг, зураглал, хэмжилтийн зураг,
- газрын зураг, GIS өгөгдөл,
- өгөгдлийн сан, 3D сэргээн босголт зэрэг орно.

Зохиогчийн эрхийн тухай хуулийн 8, 12 дугаар зүйлд зааснаар эдгээр нь шинжлэх ухаан, уран сайхны бүтээлийн ангилалд хамаарах бөгөөд туурвисан мөчөөс эхлэн зохиогчийн эрх үүснэ [3].

Монгол Улсын практикт археологийн судалгааны тайланг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 29.1-д заасны дагуу улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд шилжүүлэх үүрэгтэй. Харин 29.2-т “тайлан бүрэн эхээрээ нийтлэгдээгүй

бол түүнийг ашиглах асуудлыг Зохиогчийн эрхийн тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ” гэж заасан нь археологийн судалгааны тайлан давхар эрх зүйн дэглэмтэй болохыг илтгэнэ [5]. Өөрөөр хэлбэл тайлан нь нэг талаас төрийн мэдээллийн сангийн объект, нөгөө талаас зохиогчийн эрхийн хамгаалалттай оюуны бүтээл болдог.

Зохиогчийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлд зааснаар зохиогч дараах амины эрхийг хугацаагүйгээр эдэлнэ. Үүнд:

- зохиогч байх эрх,
- нэрээ дурдах, нэрээ ашиглуулах эрх,
- бүтээлийн халдашгүй байдлыг хамгаалах эрх [3].

Хүснэгт 2. Археологийн судалгааны бүтээгдэхүүн ба Монгол Улсад үйлчлэх оюуны өмч, соёлын өвийн эрх зүйн матриц

№	Судалгааны бүтээгдэхүүн	Оюуны өмчийн шинж	Үйлчлэх хууль	Холбогдох зүйл, зохицуулалт	Эрхийн онцлог тайлбар
1	Археологийн судалгааны тайлан (хайгуул, малтлага)	Зохиогчийн эрхийн объект	Зохиогчийн эрхийн тухай хууль; Соёлын өвийг хамгаалах тухай хууль	ЗЭХ 12, 19; СӨХТХ 29.1–29.2	Тайланг улсын бүртгэлд шилжүүлнэ; нийтлээгүй хэсгийг ашиглахад зохиогчийн эрх үйлчилнэ.
2	ЭШ өгүүлэл, ном, тайлбар	Зохиогчийн эрх	Зохиогчийн эрхийн тухай хууль	8, 12, 15	Зохиогч амины эрх эдэлнэ; ашиглах онцгой эрх гэрээгээр тодорхойлогдоно.
3	Олдворын гэрэл зураг	Зохиогчийн эрх	Зохиогчийн эрхийн тухай хууль	8, 12, 15	Фото нь зохиогчийн бүтээл; олдвор өөрөө төрийн өмч хэвээр
4	Зураглал, хэмжилтийн зураг	Зохиогчийн эрх	Зохиогчийн эрхийн тухай хууль	8, 12	Судалгааны тайлангийн салшгүй хэсэг байж болно.
5	GIS газрын зураг	Зохиогчийн эрх, өгөгдлийн эрх	Зохиогчийн эрхийн тухай хууль	8, 12, 15	Байршлын өгөгдөл эмзэг бол нууцлалын дэглэм шаардана.
6	3D модель, сэргээн босголт	Зохиогчийн эрх (дериватив бүтээл)	Зохиогчийн эрхийн тухай хууль	12, 15	Олдворын “хуулбар” биш, судалгааны оюуны бүтээл
7	Өгөгдлийн сан (database)	Зохиогчийн эрх/хөрвүүлсэн бүтээл	Зохиогчийн эрхийн тухай хууль	8, 12	Өгөгдлийн бүтэц, зохион байгуулалт хамгаалагдана.
8	VR / AR контент	Зохиогчийн эрх (цогц бүтээл)	Зохиогчийн эрхийн тухай хууль	8, 12, 15	Программ, дүрслэл, өгөгдөл нийлмэл оюуны өмч
9	Музейн тайлбар, экспозици	Зохиогчийн эрх	Зохиогчийн эрхийн тухай хууль; СӨХТХ	8, 12; СӨХТХ 33	Дэлгэн үзүүлэх, орлого олох эрхийг хууль зөвшөөрнө.
10	Сургалтын материал	Зохиогчийн эрх	Зохиогчийн эрхийн тухай хууль	8, 12	Ашиг олох эсвэл олохгүйгээс хамаарч лиценз ялгаатай
11	Бараа, дизайн (олдворын загвар)	Зохиогчийн эрх / дизайн	Зохиогчийн эрхийн тухай хууль; Патентын тухай хууль	8; ПТХ	Төрийн өмчид суурилсан арилжааны ашиглалт
12	Судалгааны арга зүй, ангилал	Зохиогчийн эрх (бичвэр)	Зохиогчийн эрхийн тухай хууль	8, 12	“Мэдлэг” өөрөө чөлөөтэй, харин бичвэр нь хамгаалагдана.

Археологийн судалгаанд археологичийн бичсэн тайлан, өгүүлэл, фото, зураглалд зохиогчийн нэрийг заавал дурдах, тайлан, өгөгдлийг хураан товчлох, өөрчлөх, хэсэгчлэн ашиглах тохиолдолд бүтээлийн утга агуулгыг гажуудуулахгүй байх юм. Монголын практикт археологийн авран хамгаалах судалгааны тайланг захиалагч байгууллага (жишээлбэл, уул уурхайн компани) өөрийн тайлан, сурталчилгаанд ашиглахдаа судлаачийн нэрийг дурдахгүй орхих, эсхүл тайлбарыг өөрчлөх тохиолдол гарч, энэ нь амины эрхийн зөрчил үүсгэх эрсдэлтэй байдаг.

Зохиогчийн эрхийн тухай хуулийн 19 дүгээр зүйл нь археологийн судалгаанд хамгийн их

маргаан үүсгэдэг зохицуулалт юм. Уг зүйлд албан үүргийн дагуу туурвисан бүтээлийн амины эрхийг зохиогч, харин ашиглах онцгой эрхийг гэрээнд өөрөөр заагаагүй бол ажил олгогч эдэлнэ гэж заасан [3].

Монгол Улсад археологийн судалгаа дараах гурван хэлбэрээр хийгддэг.

1. Төрийн байгууллага (музей) ШУА-ийн хүрээлэнгийн албан үүргийн судалгаа
 2. Авран хамгаалах судалгаа (дэд бүтэц, уул уурхай, барилга)
 3. Олон улсын хамтарсан төсөл.
- Эдгээрийн эхний хоёр хэлбэрт археологич

нь ихэвчлэн ажил олгогчийн нөөц (санхүүжилт, багаж, зөвшөөрөл) ашиглан судалгаа хийдэг тул тайлан, фото, өгөгдлийн ашиглах онцгой эрх нь байгууллагад шилжих магадлал өндөр байдаг. Үүний үр дүнд судлаач өөрийн хийсэн судалгааг өөрөө хэвлүүлэх, олон улсын сэтгүүлд илгээх эрхээ хязгаарлуулах, музей, байгууллага тайлан, фото, 3D материалыг арилжааны зорилгоор ашиглах боловч зохиогчид орлого хуваарилахгүй байх, VR контент, үзэсгэлэн, каталог зэргээс үүссэн орлогоос археологич хүртэхгүй үлдэх эрсдэлүүд үүсдэг байна.

Зохиогчийн эрхийн тухай хуульд 19.5-д “ажил олгогч бүтээлийг ашиг олох зорилгоор бусдад ашиглуулсан бол зохиогч ашигласны төлбөрөөс хүртэх эрхтэй” гэж заасан боловч практикт төлбөрийн хувь, тооцооны аргачлал тодорхойгүй учир маргаан үүсгэсээр байна. [3]. Монгол Улсад археологийн судалгааны үр дүнтэй холбоотой маргаан нь гэрээ тодорхой бус (оюуны өмчийн заалтгүй), “тайлан бол төрийн өмч” гэсэн буруу ойлголт, фото, GIS, 3D материалыг зөвшөөрөлгүй дахин ашиглах зэргээс шалтгаалдаг. Иймд археологийн судалгаанд

- судалгааны гэрээнд “оюуны өмчийн тусгай бүлэг” оруулах,
- тайлан, фото, өгөгдөл бүрээр хэний ямар эрх эдлэхийг урьдчилан тогтоох,
- арилжааны ашиглалтын үед зохиогчийн шагнал, төлбөрийн механизмыг заах шаардлага бодитойгоор тулгарч байна.

Археологийн олдвор нь төрийн өмч хэвээр хадгалагдах боловч түүнийг судалж, тайлбарлаж, баримтжуулсан оюуны үр дүн нь зохиогчийн эрхийн хамгаалалтад бүрэн хамрагддаг ч Монгол Улсад албан үүргийн бүтээлийн эд хөрөнгийн эрхийн зохицуулалтын тодорхой бус байдал нь нийтлэх, лицензжүүлэх, орлого хуваарилахтай холбоотой бодит маргаан, эрсдэлийг үүсгэсээр байна.

Биет бус хөрөнгийн эдийн засгийн үнэ цэн: Археологийн судалгааны онцлог

Археологийн судалгаанаас үүдэн бий болдог биет бус хөрөнгө нь тухайн судалгааны материаллаг олдвороос ялгаатайгаар эдийн засгийн эргэлтэд орох боломжтой оюуны үр дүнг илэрхийлнэ. Үүнд:

- зохиогчийн эрхээр хамгаалагдсан шинжлэх ухааны тайлан, өгүүлэл,
- гэрэл зураг, зураглал, GIS өгөгдөл,
- өгөгдлийн сан (database),
- 3D, VR/AR сэргээн босголт,
- судалгааны арга зүй, ангиллын систем зэрэг орно.

Олон улсын Осеан Томо-оос гаргасан судалгаагаар биет бус хөрөнгө нь орчин үеийн

байгууллага, компанийн зах зээлийн үнэ цэнийн 80 – 90 хувийг бүрдүүлж байгаа нь тогтоогдсон бөгөөд энэ хандлага нь соёл, шинжлэх ухаан, музейн салбарт ч адилхан ажиглагдаж байна. Биет бус хөрөнгө нь шууд борлогдох бараа бус боловч лиценз, үйлчилгээ, контент, нэр хүнд, өгөгдөл хэлбэрээр ирээдүйн эдийн засгийн өгөөж бий болгодогт түүний үнэ цэн оршдог [10].

Монгол Улсын хувьд археологийн судалгааны биет бус хөрөнгө нь музейн үзэсгэлэн, тайлбар, сургалтын материал, дижитал платформ, VR контент, соёлын аялал жуулчлалын бүтээгдэхүүн зэрэг хэлбэрээр эдийн засгийн эргэлтэд орж байгаа боловч эдгээрийн үнэлгээ, балансад тусгах, барьцаалах боломж нь онол практикийн түвшинд бүрэн төлөвшөөгүй байна.

Гэсэн хэдий ч Монгол Улсын Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүх төрлийн бүтээл, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдэг, ашигтай загварыг барьцааны зүйл байж болохыг зөвшөөрсөн нь (7 дугаар зүйл) оюуны өмч, түүний дотор археологийн судалгаанаас үүсэх биет бус хөрөнгийг эдийн засгийн бодит актив гэж хүлээн зөвшөөрч буй чухал эрх зүйн суурь юм [6]. Энэ нь зарчмын хувьд археологийн биет бус хөрөнгийг санхүүжилт татах, төсөл хэрэгжүүлэх, төр хувийн хэвшлийн түншлэлд ашиглах боломжийг нээж өгч байна.

Археологийн оюуны өмчийг үнэлэхэд ердийн бизнесийн биет бус хөрөнгө ялгаатай дараах онцгой хүчин зүйлс бий.

1) Төрийн өмчлөл ба эрхийн хязгаар. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу археологийн олдвор, дурсгалт газар нь төрийн өмч тул тухайн биет бус хөрөнгийн эдийн засгийн үнэ цэн нь олдворыг “зарах”, өмчлөх эрхийг шилжүүлэх боломжид суурилахгүй.

Өөрөөр хэлбэл археологийн биет бус хөрөнгийн үнэ цэн нь ашиглалтын эрх, лиценз, контентын өгөөж дээр л тулгуурлана. Энэ нь үнэлгээнд “зах зээлийн арга”-ыг шууд хэрэглэх боломжийг хязгаарладаг.

2) Ёс зүй, нийгмийн ашиг сонирхлын хязгаар. Археологийн судалгаа нь шинжлэх ухаан, соёлын нийтийн ашиг сонирхолтой шууд холбоотой. Иймээс эмзэг дурсгалын байршлын өгөгдөл, булш, шашин шүтлэгтэй холбоотой контент, дээрэм, эвдрэлийн эрсдэлтэй мэдээлэл зэргийг бүрэн арилжааны эргэлтэд оруулах боломжгүй. Энэ нь биет бус хөрөнгийн ирээдүйн орлогын урсгалыг зориуд хязгаарлаж, үнэлгээг бууруулах бодит хүчин зүйл болдог.

3) Орлого бий болгох түүхэн мэдээлэл дутмаг. Монгол Улсад археологийн VR контент, өгөгдлийн сан, лицензийн орлогоос ямар хэмжээний ашиг

олсон, хэн, хэрхэн хуваарилсан гэсэн статистик мэдээлэл байхгүй. Үүний улмаас орлогын аргаар үнэлэхэд ашиглах таамаглал ихсэж, үнэлгээний эрсдэл нэмэгддэг.

Олон улсын практикт биет бус хөрөнгийг дараах гурван үндсэн аргаар үнэлдэг [9].

- Зардлын арга (cost approach). Судалгаанд зарцуулсан бодит зардал, өгөгдөл цуглуулах, 3D модель хийх, VR бүтээх өртөг зэрэг мэдээлэлд үндэслэн үнэлдэг. Монгол Улсад археологийн судалгаанд хамгийн өргөн хэрэглэгдэх боломжтой.

- Орлогын арга (income approach). Лицензийн төлбөр, музейн тасалбар, контентын орлого, зөвхөн бодит орлогын түүхтэй (жишээ нь музейн VR үзүүлбэр) үед хэрэглэх боломжтой.

- Зах зээлийн арга (market approach). Ижил төрлийн контент, лицензийн харьцуулалт, археологийн салбарт бараг хэрэглэх боломжгүй арга юм.

Монголын нөхцөлд археологийн биет бус хөрөнгийн үнэлгээг хийхдээ зардлын арга болон хязгаарлагдмал орлогын аргыг хослуулах, үнэлгээний тайланд эрх зүйн болон ёс зүйн хязгаарлалтыг тодорхой тусгах шаардлагатай юм. Археологийн биет бус хөрөнгө нь Монгол Улсад хууль зүйн хувьд хүлээн зөвшөөрөгдсөн, эдийн засгийн бодит үнэ цэнтэй боловч онцгой хязгаарлалттай актив юм. Иймд үнэлгээ хийхдээ түүнийг “ашиг олох дээд боломж” бус, харин “нийтийн ашиг сонирхолтой нийцсэн эдийн засгийн өгөөж”-өөр ойлгох шаардлагатай юм.

Археологийн судалгаанаас үүсэх биет бус хөрөнгө нь Монгол Улсад эдийн засгийн үнэ цэн бүхий актив гэж хүлээн зөвшөөрөгдөх эрх зүйн суурьтай боловч төрийн өмчлөл, ёс зүйн хязгаарлалт, орлогын мэдээллийн хомсдолоос шалтгаалан түүний үнэлгээ нь тусгай аргачлал, болгоомжтой таамаглал шаардсан онцгой шинжтэй байна.

Хэлэлцүүлэг

Судалгааны дүнд археологийн өвийг нийтийн өмчид хамааруулах зохицуулалт болон судалгааны оюуны үр дүнд хамаарах зохиогчийн эрхийн хоорондын зөрчилд авч үзлээ. Одоогийн хууль тогтоомж нь ерөнхий зохицуулалттай боловч археологийн судалгааны үр дүнг ашиглах, үнэлэх, ашиг хүртэх асуудлыг нарийвчлан зохицуулаагүй байна. Иймд: 1. Судалгааны үр дүнгийн өмчлөл, ашиглалтын эрхийг тодорхой болгох, 2. Археологичдын хөдөлмөрийн үнэлгээг шударгаар хангах, 3. Соёлын өвийг хамгаалахтай нийцсэн эдийн засгийн эргэлтийг дэмжих бодлого шаардлагатай.

Судлаачийн хувьд археологийн судалгааны

бүтээгдэхүүнд нэг төрлийн лиценз тохиромжгүй тул олон түвшинтэй лицензийн загвар санал болгож байна. Эхлээд нээлттэй шинжлэх ухааны лицензийг эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэгдсэн тайланд хэрэглэх, хоёрдугаарт хязгаарлагдмал судалгааны лицензийг газрын зураг, байршлын өгөгдөл, нарийвчилсан фотог судлаачдад зөвшөөрлөөр, гуравдугаарт арилжааны лицензийг VR контент, музейн тайлбар, дизайныг төр болон тухайн байгууллага, зохиогчийн гурвалсан гэрээгээр хэрэгжүүлбэл мэдлэг түгээх ба өв хамгаалах хоёр зорилго тэнцвэртэй хангагдана гэж үзэж байна. Мөн соёлын өв дээр суурилсан контент нь орлого бий болгодог ч одоогийн хуульд хуваарилалтын механизм тодорхой бус байгааг Зохиогчийн эрхийн тухай хуулийн 19.5 дахь хэсэгт нийцүүлэн албан үүргийн бүтээлийн төлбөртэй нийцүүлэн тооцож болох юм. Археологийн судалгаанд оюуны өмчийн бодлого хэрэгжүүлэх нь археологичдын оюуны хөдөлмөрийг үнэлэх, судалгааны байгууллагын тогтвортой санхүүжилтийг нэмэгдүүлэх, соёлын өвийг эдийн засгийн дарамтгүйгээр хамгаалах гэсэн гурвалсан зорилгыг нэг зэрэг хангах боломжтой юм.

Дүгнэлт

Энэхүү судалгаа нь Монгол Улсад археологийн өвийг нийтийн (төрийн) өмчид хамааруулах эрх зүйн зохицуулалт болон археологийн судалгааны явцад бий болдог оюуны бүтээлд хамаарах зохиогчийн эрх хоорондын институцийн болон практик зөрчлийн тухай тодорхойлов. Соёлын өвийг хамгаалах тухай хуульд археологийн олдворыг төрийн өмч гэж хатуу тогтоосон нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үндсэн зорилготой боловч судалгааны тайлан, өгөгдөл, зураг, дижитал сэргээн босголт зэрэг оюуны бүтээлийн эрх зүйн дэглэмийг нарийвчлан зохицуулаагүй хэвээр байна [5]. Нөгөө талаас Зохиогчийн эрхийн тухай хууль нь судалгааны оюуны үр дүнг хамгаалах ерөнхий зохицуулалтыг бүрдүүлсэн боловч археологийн судалгаанд түгээмэл тохиолддог албан үүргийн дагуу хийгдсэн судалгаа, төрийн зөвшөөрөлтэй малтлага, авран хамгаалах судалгаа зэрэг онцгой нөхцөлийн эрхийн хуваарь, ашиглалт, орлогын хуваарьт механизмыг тодорхой заагаагүй нь практикт маргаан, эрсдэл үүсгэх шалтгаан болж байна [3].

Иймд археологийн судалгаанд оюуны өмчийн зохицуулалтыг боловсронгуй болгох дараах бодлогын чиглэл зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

Нэгдүгээрт, археологийн судалгааны үр дүнд бий болсон оюуны бүтээлийн өмчлөл, ашиглалтын эрхийн хуваарилалтыг хууль болон жишиг гэрээний түвшинд тодорхой болгох шаардлагатай. Ялангуяа

судалгааны тайлан, өгөгдлийн сан, дижитал контент зэрэгт аль этгээд ашиглах онцгой эрх эдлэх, ямар нөхцөлөөр лиценз олгох, ямар тохиолдолд олон нийтэд нээлттэй болгохыг тодорхойлсон тусгай зохицуулалт дутагдаж байна [3], [5].

Хоёрдугаарт, археологичдын оюуны хөдөлмөрийн үнэлгээг шударгаар хангах бодлого шаардлагатай. Зохиогчийн эрхийн тухай хуулийн 19.5-д албан үүргийн бүтээлийг ашиг олох зорилгоор ашигласан тохиолдолд зохиогч ашигласны төлбөрөөс хүртэх эрхтэй гэж заасан боловч төлбөрийн хувь, тооцооны аргачлал тодорхой бус хэвээр байна [3]. Энэ нь судлаачдын мэргэжлийн урамшуулал, судалгааны чанарт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй тул салбарын онцлогт тохирсон орлого хуваарилалтын жишиг загвар боловсруулах шаардлагатай.

Гуравдугаарт, соёлын өвийг хамгаалах үндсэн зорилготой нийцсэн эдийн засгийн эргэлтийг дэмжих бодлого хэрэгтэй байна. Археологийн судалгаанд суурилсан музейн тайлбар, дижитал архив, VR контент, сургалтын материал зэрэг нь соёлын өвийг арилжаалах бус, харин түүнийг хамгаалах, түгээх, олон нийтэд хүртээмжтэй болгох хэлбэрээр эдийн засгийн өгөөж бий болгодог. Иймд “хамгаалалт, хүртээмж, эдийн засгийн өгөөж” гэсэн гурвалсан тэнцвэрийг хангах шаталсан лиценз, өгөгдлийн нээлттэй байдлын бодлого нэн шаардлагатай байна [5].

Дээрх бодлогын чиглэлүүдийг хэрэгжүүлснээр археологийн өвийг нийтийн өмч хэвээр хамгаалах, судлаачдын оюуны хөдөлмөрийг үнэлэх, соёлын өв дээр суурилсан тогтвортой мэдлэгийн эдийн засгийг хөгжүүлэх эрх зүйн суурь бүрдэх боломжтой юм.

Ашигласан материал

- [1] Монгол Улсын Үндсэн хууль.
- [2] Монгол Улсын Оюуны өмчийн тухай хууль, 2020.
- [3] Монгол Улсын Зохиогчийн эрхийн тухай хууль, 2021.
- [4] Монгол Улсын Патентын тухай хууль, 2021.
- [5] Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль.
- [6] Монгол Улсын Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай, 7 дугаар зүйл.
- [7] A. Van Assche, “Trade, investment and intangibles: The ABCs of global value chain-oriented policies,” OECD Trade Policy Papers, no. 242, OECD Publishing, 2020.
- [8] Global Intangible Finance Tracker, 2017.
- [9] ICC, Handbook on Valuation of Intellectual Property Assets, 2019.

[10] Ocean Tomo, Intangible Asset Market Value Study, 2020.

[11] UNESCO, “The Missing SDG: UNESCO Launches the First UNESCO Global Report on Cultural Policies,” 2025. [UNESCO](https://www.unesco.org/en/culture/policies)



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>